



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим худас: www.mojha.gov.mn

2024.12.19 № 1/2446
танай _____ -ны № _____ -т


МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
П.ОДГЭРЭЛ ТАНАА

Санал авах тухай

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулан хүргүүллээ.

Тушаалын төсөлтэй танилцан саналаа ирүүлнэ үү.

Хавсралт *9* хуудастай.



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны ... дугаар
сарын ... -ний өдөр

Дугаар ... / ...

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүснэгт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам"-д доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/1.5 дахь хэсэг:

"1.5.Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүн нас барсан бол хохирогчоор тогтоогдсон гэр бүлийн гишүүний сэтгэцэд учирсан хор уршгийг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.4, 511.5-д заасны дагуу тогтооно."

2/2.6¹, 2.6² дахь хэсэг:

"2.6¹.Сэтгэцийн эмгэгийн улмаас өвчин сэдэрсэн, гэмт хэргийн нөхцөлөөс шалтгаалан ухамсарт ухааны алдагдалд орж нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийж болзошгүй мөн шинжлүүлэгч ухаангуй тохиолдолд сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээг хойшлуулж болно.

2.6².Бага насы (0-3 нас) хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтооход эмчийн үзлэг, лабораторийн болон багажийн шинжилгээ, эцэг эх, асран хамгаалагчийн өгүүлэлмж, сэтгэл зүйч болон сэтгэцийн шинжээч эмч нарын ажиглалт зэргийг үндэслэнэ."

2.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам"-ын дараах хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/2.1, 2.2 дахь хэсэг:

"2.1.Гэмт хэргийн хохирогчийн хувь хүний сэтгэцийн хариу урвалын байдал, гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл, эд хөрөнгөө алдсанаас хохирогчид учрах сэтгэцийн түр зуурын, эсхүл байнгын шинжтэй эмгэг өөрчлөлт, хэвийн амьдрал алдагдсан байдал, шаардагдах эмчилгээний дундаж хугацаа, хөдөлмөрийн чадвар алдалт зэрэг шалгуур үзүүлэлтийг болон "Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт"-ийг (цаашид "хүснэгт" гэх) баримтлан дараах гэмт хэргийн хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шүүх шинжилгээний байгууллагаас тогтоох ба мөрдөгч уг хүснэгтийг ашиглан энэ журмын 2.3-д заасан ажиллагааг явуулж болно:

2.2. Энэ журмын 2.1.1-2.1.5-д заасан гэмт хэргийн хохирогчдод энэ журмын 2.1-д заасан хүснэгтийг баримтлан сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтооно.”

2/2.7 дахь хэсэг:

“2.7. Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох шинжилгээг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн сэтгэцийн эмч, сэтгэл зүйчээс бүрдсэн шинжээчийн багаар хийлгэнэ.”

3/2.10 дахь хэсэг:

“2.10. Энэ журмын 2.1.1.-2.1.5 зааснаас бусад Шүүх шинжилгээний тухай хуулийн 40.1-д заасан гэмт хэргийн хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шинжилгээний байгууллага шинжилгээ хийж тогтооно.”

4/5.4 дэх хэсэг:

“5.4. Хохирогчид илэрсэн эмгэг өөрчлөлт, багажийн болон лабораторийн шинжилгээний хариу, эмнэлгийн баримт бичиг, бусад матэриалыг нэйтгэн үнэлж үзсэний үндсэн дээр сэтгэцийн эмч, сэтгэл зүйчээс бүрдсэн шинжээчийн баг гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож дүгнэлт гаргана.”

3.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ын 3.3 дахь хэсгийн “2.7” гэснийг “2.8” гэж өөрчилсүгэй.

4.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ын 2.5 дахь хэсгийг хассугай.

5.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

6.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Мягмар), Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат) нарт тус тус даалгасугай.

7.Энэ тушаал баталсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

Т.МОНХСАЙХАН

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн
сайдын 2024 оны / дугаар хамтарсан
тушаалын хавсралт

ТУХАЙЛСАН ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООХ ХҮСНЭГТ

СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ТАВДУГААР ЗЭРЭГЛЭЛ			
Шалгуур үзүүлэлт	Хувь хүний сэтгэцийн хариу урвал	Хүний эрүүл мэндэд учирсан хүнд зэргийн хохирол	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг
Гэмтлээс үүдэлтэй үлдэц	Гэмт хэргийн улмаас насан туршид эргэшгүй мэдрэл, сэтгэцийн голомтот органик өөрчлөлт бий болох.	Гэмтлийн улмаас хараагүй, сонсголгүй, хэлгүй болов, зарим эрхтэнгүй болох буюу тэдгээрийн үйл ажиллагаа бүрэн алдагдах, жирэмслэлт таслагдах, нүүр засаршгүй гэмтэж, нүүрний төрх алдагдах, сэтгэцийн болон донтох өвчтэй болгох, гэмтлийн шалтгаант уналт таталт, тэнэргэл, токсикомани, наркомани болгох.	
Танин мэдэхүйн талаас илрэх өөрчлөлт	Сэтгэц органик хам шинж, ойгүйдэл илрэх, танин мэдэхүйн үйл ажиллагааны хурд удаашрах, анхаарлын шилжилт үгүй болох	Хөдөлмөрийн өрөнхий чадвар их хэмжээгээр тогтонги байдлаар алдагдах гэмтэлд сүүж ясны тогооны зөрөөтэй хугарал, атгаалын үен доторх /толгой/, үе орчмын /анатомийн хүзүү, төвгөрийн доорх ба төвгөр дайрсан хугарал/, дунд чөмгөний толгой, хүзүүний үен доторх хугарал /толгой хүзүүний хугарал/, тохойн үе үүсгэгч яснуудын ил хугарал, өвдөгний үе үүсгэгч яснуудын /тойгоос бусад/ ил хугарал, шагайн үеийг үүсгэхэд оролцох шаант ясны гадна ба дотор хавчаар ясны ил хугарал нь шагайн үений бүрэн мултрантай хавсарсан гэмтэл, хоёр ба түүнээс дээш мөчдийн гурваас дээш чөмөгт ясны далд хугарал, мэргэжлийн хөдөлмөрийн чадварын тогтонги алдалт, өрөнхий хөдөлмөрийн чадвар тогтонги их хэмжээгээр буюу 35%-100% алдагдах нь хамаарна.	Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хохирогчид гэмтлээс үүссэн үлдэц уршилт бүхий гэмтэл учрах, мэргэжлийн хөдөлмөрийн чадварын тогтонги алдалт, өрөнхий хөдөлмөрийн чадвар тогтонги 35 хувиас дээш алдагдсан байх.
Нийгмийн харилцааны талаас илрэх өөрчлөлт	Нийгмийн харилцаанд бие даан оролцох, урч хөдөлмөрлөх чадвар насан туршид алдагдах.		
Төрх үйлийн талаас илрэх өөрчлөлт	Биеэ хянах, шийдвэр гаргах чадвар бүрэн алдагдах.		
Сэтгэл хөдлөлийн талаас илрэх өөрчлөлт	Сэтгэл хөдлөлөө хянах, удирдах чадвар бүрэн алдагдах.		
Билемхбодийн талаас илрэх өөрчлөлт	Нүүрний хөдөлгөөн байхгүй байх, хөдөлгөөн хязгаарлагдмал болох.		

СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ДӨРӨВДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛ

Шалгуур үзүүлэлт	Хувь хүний сэтгэцийн хариу урвал	Хүний эрүүл мэндэд учирсан хүнд зэргийн хохирол	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг

Гэмтлээс үүдэлтэй үлдэц	Гэмт хэргийн улмаас удаан хугацаанд үргэлжлэх хэдий ч эргэн сэргэх боломж бүхий голомтот ёөрчлөлт бий болох.	Гэмтэл учрах үедээ амь насанд аюултай, амь тэнссэн байдалд оруулж эмнэлгийн яаралтай тусламжийн үр дүнд амь нас нь аврагдсан гэмтлүүд хамаарна.	
Танин мэдэхүйн талаас илрэх ёөрчлөлт	Сэтгэн бодох, ярихад бэрхшээлтэй болох, хэсэгчилсэн ойгүйдэл илрэх, сэтгэлийн гэмтэл учруулсан үйл явдлын талаар бодол санаанаас гарахгүй байдал удаан үргэлжлэх.	Энэ нь тухайн гэмтлийн төрөл, цар хэмжээ, гэмтэл авсан нөхцөл, хүний бие махбод, эрхтэн тогтолцооны онцлог зэрэг олон нөхцөлөөс шалтгаалдаг. Харин энэхүү амь насанд аюултай, амь тэнссэн байдлаас гарсны дараа онцгой мэдэгдэх үлдэцгүй байж болно.	Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хохирогчид амь насанд аюултай, амь тэнссэн байдал бүхий гэмтэл учрах
Нийгмийн харилцааны талаас илрэх ёөрчлөлт	Ажил эрхлэх, сурх чадвар удаан хугацаанд алдагдах.	Энэ тохиолдолд зайлшгүй эмнэлгийн яаралтай тусламжийн үр дүнд амь нас нь аврагдсан тухай эмнэлгийн бичиг баримтад тусгагдсан байх шаардлагатай.	
Төрх үйлийн талаас илрэх ёөрчлөлт	Органик гаралтай бие хүний эмгэг илрэх, зан байдлаа хянахад бэрхшээлтэй байх, хэт хөдөлгөөнтөх, хөдөлгөөнгүйдэх.	Мөн ердийн явцаараа үхэлд хүргэдэг гэмтлүүд багтана. Зарим гэмтлүүд өөрийн жам ёсны шалтгаант холбоо бүхий хүндрэлээр үхэлд хүргэдэг буюу үхэлд хүргэх амь тэнссэн байдал үүсгэдэг.	
Сэтгэл хөдлөлийн талаас илрэх ёөрчлөлт	Сэтгэл хөдлөлийн тохиороо алдагдах, дур хүсэл ихсэх, огт үгүй болох.	Энэ нь гэмтэл үүссэн даруйдаа бус тодорхой хугацаа өнгөрсний дараа илэрч болно.	
Билемахбодийн талаас илрэх ёөрчлөлт	Гэмт хэргийн улмаас архаг нойргүйдэлд орох, зүрх судасны системийн үйл ажиллагаанд эрсдэл учрах.		

СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ГУРАВДУГААР ЗЭРЭГЛЭЛ

Шалгуур үзүүлэлт	Хувь хүний сэтгэцийн хариу урвал	Хүний эрүүл мэндэд учирсан хүндэвтэр зэргийн хохирол	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг
Гэмтлээс үүдэлтэй үлдэц	Гэмт хэргийн улмаас удаан хугацаанд үргэлжилсэн ужиг хариу урвал илрэх	Гэмтлийн улмаас үүссэн эд эрхтний, цашилбал тогтолцооны бүтэц, үйл ажиллагааны хямрал нь арилж, эдгэрэх, үйл ажиллагаа хэвийн болох хүртэл дөрвөн долоо хоногоос дээш буюу удаан хугацаагаар үргэлжилнэ.	Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3 дахь хэсэг,
Танин мэдэхүйн талаас илрэх ёөрчлөлт	Сэтгэн бодох, ярих хурд удаашрах, хэргийн нөхцөл байдалтай холбоотойгоор анхаарал төвлөрөхгүй байдал тогтвортой үргэлжлэх, ой тогтоолтын ёөрчлөлт.	Мөн гэмтлийн улмаас өрөнхий хөдөлмөрийн чадвар үлэмж хэмжээгээр буюу 15-30%-аар тогтонги алдагдах хамаарна.	27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

Нийгмийн харилцааны талаас илрэх өөрчлөлт	Сурч хөдөлмөрлөх чадвар буурах, өөрийгөө арчлах чадвар хэсэгчлэн алдагдах.		
Төрх үйлийн талаас илрэх өөрчлөлт	Түрэмгий авир гаргах, биеэ хянах чадвар сулрах.		
Сэтгэл хөдлөлийн талаас илрэх өөрчлөлт	Гэнэтийн, хүчтэй айдас байнга тэрөх, сэтгэлээр унах шинжүүд үргэлжлэх, цочмог хариу урвал узуулэх.		
Билемахбодийн талаас илрэх өөрчлөлт	Бэлгийн болон хооллох дур өөрчлөгдөх, нойргүйдэл, симпатик мэдрэлийн хөөрөл удаан хугацаанд үргэлжлэх.		

СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ХОЁРДУГААР ЗЭРЭГЛЭЛ

Шалгуур үзүүлэлт	Хувь хүний сэтгэцийн хариу урвал	Хүний эрүүл мэндэд учирсан хөнгөн зэргийн хохирол	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг
Гэмтлээс үүдэлтэй үлдэц	Гэмт хэргийн улмаас стрессийн үед үзүүлэх хариу урвал хэвийн хэмжээнээс удаан үргэлжлэх.		
Танин мэдэхүйн талаас илрэх өөрчлөлт	Хэргийн нөхцөл байдалтай холбоотойгоор анхаарал төвлөрөлт муудах, ой тогтоолт хоёрдогчоор буурах, сэтгэхүйд илэрхий өөрчлөлт үгүй байх.	Гэмтлийн улмаас үссэн эд эрхтний, цаашилбал тогтолцооны бутэц, үйл ажиллагааны хямрал нь арилж, эдгэрэх, үйл ажиллагаа хэвийн болох хүртэл дервэн долоо хоногоос доош буюу түр хугацаагаар үргэлжилнэ.	Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дахь хэсэг, 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3 дахь хэсэг, 17.12 дугаар зүйлийн 1 дахь хэсэг
Нийгмийн харилцааны талаас илрэх өөрчлөлт	Ажил эрхлэх, сурх идэвх сонирхол буурах.	Мөн гэмтлийн улмаас ерөнхий хөдөлмөрийн чадвар үлэмж хэмжээгээр буюу 5-10%-аар тогтонги алдагдах хамаарна.	
Төрх үйлийн талаас илрэх өөрчлөлт	Дасан зохицохуйн хямрал үүсэх.		
Сэтгэл хөдлөлийн талаас илрэх өөрчлөлт	Сульдал, неврозын хам шинж илрэх, сэтгэлээр унах, түгших.		
Билемахбодийн талаас илрэх өөрчлөлт	Хөнгөн зэргийн нойргүйдэл, амьсгал бачуурах, булчин чангараах зэрэг		

	симпатик мэдрэлийн хөөрөл илрэх.		
СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛ			
Шалгуур үзүүлэлт	Хувь хүний сэтгэцийн хариу урвал		Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг
Гэмтлээс үүдэлтэй үлдэц	Гэмт хэргийн улмаас стрессийн үед үзүүлэх хэвийн хариу урвал илэрч, богино хугацаанд ургэлжлэх.		
Танин мэдэхүйн талаас илрэх өөрчлөлт	Үйл явдлаас үүдэлтэй анхаарал төвлөрч чадахгүй байх, мартах, сэргээн санах оновчтой байдал түр зуур сулрах, сэтгэхүй, уг ярианд өөрчлөлт үгүй байх.		
Нийгмийн харилцааны талаас илрэх өөрчлөлт	Сурч хөдөлмөрлөх чадвар хэвийн байх.	Хүний эрүүл мэндэд учирсан хохиролгүй.	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
Төрх үйлийн талаас илрэх өөрчлөлт	Өөрийн зан байдлыг хянах, шийдвэр гаргах чадвар харьцангуй хэвийн, өөрийн сэтгэл санааны байдлыг бодитоор үнэлэх байдал сул байж болно.		
Сэтгэл хөдлөлийн талаас илрэх өөрчлөлт	Амархан гомдох, мэдрэмтгий болох.		
Билемахбодийн талаас илрэх өөрчлөлт	Өөрчлөлтгүй.		

Жич: Сэтгэцийн талаас илрэх шинж тэмдгүүд нь зэрэглэл буурахад давхардан илрэхгүй болно. Жишээлбэл, гэмтлээс үүдэлтэй үлдэц гэсэн шалгуур үзүүлэлтийн 5-р зэрэглэлд байгаа шинжүүд 4-р зэрэглэлийн үед илрэхгүй.

"Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршигийн зэрэглэлийг тогтоох хүснэгт"-ийг хэрэглэх үед шинжлүүлэгч сэтгэцэд учирсан хор уршигийн зэрэглэлийг хүлээн зөвшөөрөхгүй бол шинжилгээний байгууллагаар шинжилгээ хийлгэж тогтоолгох бөгөөд шинжлүүлэгч өөрийн сэтгэл зүйн байдлыг муугаар харуулах гэсэн оролдлого, бие хүний онцлог, аргачлалын итгэгдэх чанарын үзүүлэлтүүд зэргээс хамааран зэрэглэл өөрчлөгджэж тогтоогдож болно.

ТАНИЛЦУУЛГА

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хуулийн 80 дугаар зүйлийн 80.6-д “сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх, хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгуулах”-тай холбоотой зохицуулалтыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан. Үүнтэй холбогдуулан уг хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”, болон уг тушаалын хоёрдугаар хавсралтаар “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт”-ийг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах, шинжилгээ хийх үйл ажиллагааг зохицуулж байна.

Мөн “Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох аргачлал”-ыг баталж, хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

Нийслэлийн шүүх анааах ухааны шинжилгээний хэлтсийн шүүх сэтгэцийн шинжилгээний тасагт 2023 оны 07 дугаар сарын 01-нээс 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэл нийт 1490 тогтоол шийдвэр хүлээн авч ажиллаж байна. Үүнд:

№	Эрүүгийн хуулийн тусгай анги	2024 он	2023 он
1.	10 дугаар бүлэг. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	4	
2.	11 дүгээр бүлэг. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 11.6.1,11.6.2	446	84
3.	11 дүгээр бүлэг. 7 дугаар зүйл Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	18	
4.	12 дугаар бүлэг Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12.1,12.2,12.3,12.5	426	112
5.	27 дугаар бүлэг. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	103	34
6.	17 дугаар бүлэг. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 17.1,17.2,17.3	23	
7.	13 дугаар бүлэг. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	10	10
8.	20 дугаар бүлэг. Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	3	-
Албан бичгээр буцаасан		337	144

1.	Үзлэг шинжилгээнд өөрийн биеэр ирж хамрагдаагүй	127	
2.	Хууль ёсны төлөөлөгч	210	
.	Давтан шинжилгээ	13	-
1.	Шүүхийн тогтоол	3	
2.	Мөрдөгчийн тогтоол	9	
3.	Прокурорын тогтоол	1	
	Үзлэг, шинжилгээнд хамрагдсан	765	240
1.	Зэрэглэл тогтоогдоогүй	35	4
2.	Нэгдүгээр зэрэглэл	160	13
3.	Хоёрдугаар зэрэглэл	343	102
4.	Гуравдугаар	168	95
5.	Дөрөвдүгээр зэрэглэл	28	14
6.	Тавдугаар зэрэглэл	11	12
7.	Үзлэг шинжилгээнд хамрагдан дүгнэлт гаралаагүй	20	-

Хуулийн практикт шинээр нэвтэрч буй “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршигийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гарах журам”-ын зүйл, заалтууд нь өөр хоорондоо болон Шүүх шинжилгээний тухай хууль, Иргэний хуулийн зүйл, заалтуутай зөрчилдэх байна.

Уг журмыг хэрэгжүүлж ажиллахад практик дээр зөрчилдөх, утга найруулгын хувьд буруу ойлгогдох, шинжилгээ хийхэд зарим асуудал тулгарч байгаа тул дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тушаалын төслийг боловсруулсан:

1.Журмын дагуу энэ төрлийн шинжилгээг хийж эхэлснээс хойш насанд хүрээгүй буюу 0-3 насны хохирогчид шинжилгээ хийхэд тухайн үед болсон гэмт хэргийн үйл явдлыг санаахгүй, мөн хуухдийн насны онцлогоос хамааран асуусан асуултыг бүрэн ойлгож хариулж чадахгүй, өөрийн мэдрэмж болон тухайн нөхцөл байдлаа үнэлж, үгээр илэрхийлэх чадвар бүрэн хөгжөөгүй зэрэг хүндрэлтэй асуудлууд гарсан. Мөн ухаангүй, хүнд, эсхүл сэтгэцийн хурц хэлбэрийн өвчний үед сэтгэцийн шинжилгээ хийх боломжгүй бөгөөд уг журамд ухаангүй болон сэтгэцийн хурц хэлбэрийн өвчний үед шинжилгээ хийх талаар тусгагдаагүй учир тухай бүрд нь шийдэж чадалгүй буцаасан тохиолдол гарад байна.

Иймд сэтгэцийн өвчний хурц хэлбэрийн үед өөрт болон бусдад, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй байдаг мөн ухаангүй өвчтөн нь ярилцлага, сорилд оролцох чадваргүй учир сэтгэцэд учирсан хор уршигийн зэрэглэл тогтоох шинжилгээг түр хойшилуулах, бага насны /0-3/ хүүхэд нь өөрийгөө илэрхийлэх, ойлгуулах чадвар сүл тул шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа бусад эмчийн үзлэг, шинжилгээ, болон асран хамгаалагчдийн өгүүлэлмэжээр хийх зохицуулалтыг нэмж, “2.61” болон “2.62” гэх заалт болгон оруулсан.

2.Журмын 2.5 дахь хэсгийг тус журмын нийтлэг үндэслэлд нэмж оруулсан.

3.Журмын 2.1, 2.2, 2.7, 2.10, 3.3 дахь хэсэгт үг өгүүлбэр, утга найруулгыг зассан.

4.Шинжлүүлэгчдийн дийлэнх хувь нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай байна. Одоо мөрдөгдөж байгаа журамд сэтгэцийн шинжээч эмч “олон улсын өвчний ангиллын

дагуу онош тавина” гэсэн нь практиктай зөрчилдөж байна. Иймд журмын 5.4 дахь хэсгийг өөрчлөн найруулсан.

5. Тус журмын 2 дугаар хавсралтаар баталсан “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох хүснэгт”-д зөвхөн сэтгэцэд учирсан хор уршиг, өөрчлөлттэй холбож тусгасан байсныг өөрчилж, гэмт хэргийн улмаас хүний бие махбодид учирсан гэмтлийн зэргийн шалгуур үзүүлэлтийг харгалзан шинэчилсэн болно.

---оОо---